Журмын 5 дугаар хавсралт

**АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

( 2020 оны жилийн эцсийн байдлаар ) САЙНЦАГААН СУМ

| № | Хөтөлбөр/төслийн агуулга | Гүйцэтгэл | | | |
|---|---|---|---|---|---|
| 1. | Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар | Аймгийн засаг даргын 2020 оны 01 сарын 16 ны өдөр баталсан төлөвлөгөөний дагуу сумын төлөвлөгөөг боловсруулаа. | | | |
| 2. | Санхүүжилтийн эх үүсвэр | Орон нутгийн төсвөөс | | | |
| 3. | Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа | Дундговь аймаг Сайнцагаан сумын ЗДТГазар<br>ЗДТГазрын харъяа төсөвт байгууллагууд, 9 багийн иргэд | | | |
| | Төсөл, хөтөлбөрийн зорилтууд | **Зорилт 1.** Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах<br>**Зорилт 2.** Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах<br>**Зорилт 3**. Төсөв,санхүүгийн үйл ажиллаганы удирдлага,хяналтыг сайжруулж,ил тод байдлыг хангах,төсвийн хөрөнгө,гадаадын зээл тусламжийг үр ашигтай,зориулалтын дагуу зарцуулах,хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах<br>**Зорилт 4.** Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах<br>**Зорилт 5.** Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах чиглэлээр<br>**Зорилт 7.** Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах<br>**Зорилт 10.** Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах<br>**Зорилт 11.**Авилгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан шинэлэг ажил | | | |
| 5 | Зардал | Төсөв (нийт шаардагдах зардал) | | | |
| | | Үүнд: | Төсөв (он) | Гүйцэтгэл | Хувь |
| | | Багц 1 | 300.000 | 110.000 | 36.6% |
| | | Багц 2 (г.м) | | | |

| | | |
|---|---|---|
| 6 | Төсөл, хөтөлбөрийн зорилт: | |
| | 1-р зорилтын хүрээнд:<br><br>Хүрэх үр дүн 1: | Сумын Хүмүүнлэг сургуулийн захирал Д.Мөнхбат, 6-р цэцэрлэгийн эрхлэгч Д.Энхмаа, Хүмүүнлэг сургуулийн сургалтын менежер Ц.Ариунтунгалаг, Н.Баттунгалаг, Цэгц билэг сургуулийн сургалтын менежер Ж.Баяртогтох, ГИЦСургуулийн сургалтын менежер Д.Бадамцэцэг, Ж.Баярхүү, сумын Далай, Арвижих, Нарлаг, Айраг, Мандал багийн багийн засаг дарга нарын нийтийн албанд нэр дэвшигчдийн ХАСУМ-ийг цахимаар АТГазарт хянуулан хуулийн хугацаанд томилгоог хийлгэн, ХАСХОМ-ийг хугацаанд нь цахимд бүртгэлээ.<br>Энэ онд засаг даргын захирамжаар өндөр насны тэтгэвэрт гарсан 1 багийн засаг даргыг ажлаас чөлөөлж, 5 багийн засаг даргыг томилсон, ЗДТГазрын даргын тушаалаар 5 албан хаагчийг томилж, 6 албан хаагчийг ажлаас чөлөөлсөн байна. Албан хаагчдын үйл ажиллагааг хагас жил тутам шалгуурын дагуу дүгнэлээ. Сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагч байхгүй. ЗДТГазрын албан хаагчид болон харьяа байгууллагын 14 удирдлагатай ёс зүйн гэрээ байгуулан дүгнэлээ. ЗДТГазрын дарга,ХАА-н төсгийн 2, Санхүүгийн албаны 2 мэргэжилтний ажлын байрны захиалгыг хүргүүллээ.<br>**Үр дүн: Хуулийн зөрчилгүй ажиллалаа.** |
| | 2-р зорилтын хүрээнд:<br><br>Хүрэх үр дүн 1: | Даваа гараг бүрт байгууллагын цуглаан хийж,өмнөх 7 хоногийн ажлын гүйцэтгэлийг ярилцаж хэвшлээ. Мөн сумын болон харьяа байгууллагын удирдлагуудын хамаарал бүхий этгээдийн судалгааг гарган самбарт байршуулж, сумын цахим хуудсаар иргэдийн гомдол ирээгүй. Аймгийн 7059106 утсанд халаалт, хог, золбин нохойтой холбоотой гомдол ирснийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлэлээ. Тус ЗДТГазрын хувьд ачаалал харьцангуй их байдаг ч үйлчилгээний хүртээмжийг шуурхай байхад анхаарч, албан хаагчдын ёс зүйн гэрээ, албан тушаалын тодорхойлолтын дагуу ажиллахад хяналт тавилаа. Албан хаагчдаар өөрийн ёс зүйг үнэлүүлж, хариуцсан ажлын гүйцэтгэлийг удирдлагууд, албан хаагчид тусгай шалгуураар үнэллээ.<br>**Үр дүн: Албан хаагчдын ёс зүйтэй холбоотой гомдол гараагүй байна.** |
| | 3-р зорилтын хүрээнд:<br><br>Хүрэх үр дүн 1: | Энэ онд нийт 34 худалдан авах ажил, арга хэмжээг төлөвлөн хуулийн хугацаанд буюу төсөв батлагдсанаас хойш 5 хоногийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчаар батлууллаа. Төлөвлөгөөг tender.gov.mn болон шилэн дансны сайтад ил тод байрлуулан үр дүн, хэрэгжилтийг тогтмол оруулан олон нийтэд мэдээллээ. Үүнээс 22 ажил, арга хэмжээ, аймгаас эрх шилжиж ирсэн 5 ажил нийт 27 ажлын тендер зарлахаар төлөвлөснөөс одоогийн байдлаар 23 тендерийг хуулийн дагуу зохион байгууллаа. Эдгээр зохион байгуулсан тендерүүдийг цахим систем буюу tender.gov.mn системээр амжилттай зарлагдаад байна. Зарлагдаагүй байгаа 4 тендер нь Монгол улсад үүссэн цар тахлын улмаас хойшлогдож, зарлагдах бэлтгэл ажил хийгдэж байна.<br>**Үр дүн:Шилэн дансны мэдээлэл тогтмолжиж, төрийн аудитээс зөрчилгүй дүгнэгдлээ.** |
| | 4-р зорилтын хүрээнд: | Төрийн болон ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн 23 ажлыг цахимд бүрэн оруулж, үнэлгээний хорооны болон тендерт оролцогчдын мэдээллийг цахимд байршуулсан ба зөрчил гомдолгүй ажиллалаа. Холбогдох байгууллагуудаас 2 удаа хяналт шалгалт хийгдлээ. Зөрчил гараагүй болно. Нийт 23 үнэлгээний хороо хууль журмын дагуу засаг даргын захирамжаар |

<table>
<tr><td></td><td></td><td colspan="10">байгуулагдан ажиллалаа. Үр дүн: Худалдан авах ажиллагааны ил тод байдал хангагдлаа.</td></tr>
<tr><td></td><td>5-р зорилтын хүрээнд:</td><td colspan="10">Цахимаар ХАСУМ, ХАСХОМ-ийг мэдүүлж хэвшлээ. Засаг даргын захирамж, ЗДТГазрын даргын тушаал сар бүр гарган шилэн дансанд байршуулллаа. Үр дүн: Хуулийн дагуу хугацаанд нь тайлагнадаг.</td></tr>
<tr><td></td><td>7-р зорилтын хүрээнд:</td><td colspan="10">Удирдах 14 албан тушаалтнуудын хамаарал бүхий 19 этгээдүүдийн судалгааг гарган ХЭЗХэлтэст хугацаанд нь хүргүүллээ.Үр дүн: Зөрчил гараагүй ажиллалаа.</td></tr>
<tr><td></td><td>10-р зорилтын хүрээнд:</td><td colspan="10">Багийн ИНХурлаар баг бүрт 1 удаа сургалтыг зохион байгуулж, сургалтанд 1516 иргэн хамрагдлаа. Харьяа байгууллагын удирдлагууд албан хаагчдадаа 1 удаа сургалт явууллаа. ХЭЗХэлтсээс ирүүлсэн шторк, гарын авлагыг байгууллага, иргэдэд цахимаар хүргэлээ. Цаг үеийн байдлаас шалтгаалан зарим арга хэмжээ явагдаагүй. Үр дүн: Албан хаагч,иргэд мэдээлэлтэй болсон.</td></tr>
<tr><td></td><td>11-р зорилтын хүрээнд:</td><td colspan="10">Харьяа байгууллагын удирдлагууд,багийн засаг дарга нар “Авилгагүй нийгмийн төлөө хамтдаа” уриалгад нэгдлээ. би авилга өгөхгүй авахгүй энгэрийн тэмдгийг мэргэжилтнүүдэд олгож, нийтийн албанд хуулийг хэрэгжүүлэн ажиллалаа.</td></tr>
<tr><td>7.</td><td>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</td><td colspan="10">1.Шинээр цахим программтай болсон нь ололттой ч ЭБАТ-ыг зөвлөмжөөр хангах<br>2.АТГазраас мэдээлэл,тусламж авахад хүндрэл байна./Утсаа авахгүй,олон дамжлагатай,өгч байгаа мэдээлэл нь дутмаг, цааргалсан өнгө аястай /</td></tr>
<tr><td>8.</td><td>Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ</td><td colspan="10"></td></tr>
<tr><td rowspan="2">9.</td><td rowspan="2">Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)</td><td>Биелэлт дундаж</td><td>Зорилтын тоо</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>7</td><td>10</td><td>11</td></tr>
<tr><td>88.7%</td><td>8</td><td>100%</td><td>100%</td><td>100%</td><td>70%</td><td>100%</td><td>100%</td><td>70%</td><td>70%</td></tr>
<tr><td rowspan="2">10.</td><td rowspan="2">Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ<br>(ЗГХЭГ-ын үнэлгээ)</td><td colspan="10">Нэгдсэн үнэлгээ</td></tr>
<tr><td colspan="10">... %</td></tr>
</table>

САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР